



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2020.08.28 № 10

Асуулга тавих тухай

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Тавантолгойн бүлэг ордоос өнөөдрийн байдлаар олон улсын зах зээлд гаргах нүүрс тээвэрлэх зориулалтаар хэрэгжиж буй төмөр замын болон авто замын 4 төсөл, хэрэгжихээр төлөвлөгдөөд буй авто замын 3 төсөл байна. Дээрх төслүүд нь Өмнөговь аймгийн нийт газар нутгийн 50 орчим хувийг хамарч, тухайн нутагт ажиллаж, амьдарч буй малчид, иргэдийн аж амьдрал, байгаль орчны тэнцвэртэй байдал алдагдахад хүргэж, хөрөнгө оруулагч, гүйцэтгэгч тал, орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд, малчид, иргэдийн дунд зөрчил үүсч даамжирсаар байгаа юм.

Монгол улсын нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхүйц төсөл, хөтөлбөрүүдийг Өмнөговь аймаг, тухайн бүс нутгийн малчид, иргэд тухай бүрт нь дэмжиж ирсэн ч сүүлийн жилүүдэд хэрэгжихээр төлөвлөгдөөд байгаа “Тавантолгой-Барууннаран чиглэлийн замын төгсгөлөөс Цагаандэл уул-Өлзий боомт хүртэлх авто зам” төсөл болон “Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам” төсөл, “Тавантолгой-Шивээговь хүртэлх нүүрс тээврийн замын төсөл”-үүд нь хууль, эрх зүйн хүрээнээс давсан үйл ажиллагаа явуулж, тухайн бүс нутгийн иргэдийн оролцоо, саналыг үл харгалзсан үйлдэл нь иргэдийг төрийн бодлого, шийдвэрт эргэлзэх, зөрчилдөх асуудлууд гарах үндэс суурь нь болоод байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд асуулга тавьж байна.

1. “Тавантолгой-Барууннаран чиглэлийн замын төгсгөлөөс Цагаандэл уул-Өлзий боомт хүртэлх авто зам” төсөл болон “Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам” төсөл нь Авто замын тухай хуулийн 18, 19, 20, 21 дүгээр зүйлүүдэд заасан шаардлага, “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын 4 дүгээр хавсралтын А-д заасан шаардлага, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7, 8, 18 дугаар зүйлүүдэд заасан шаардлага, Концессын тухай хуулийн 11-19 дүгээр зүйлүүдэд заасан шаардлага, “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах


2020000056

тухай журам"-д заасан шаардлагуудыг тус тус хангаж байгаа эсэх, энэ талаар холбогдох төрийн байгууллагуудын санал, дүгнэлт гарсан эсэх талаар; /дээрх бичиг баримтуудыг асуулгын хариуд хавсаргаж ирүүлэх/

2. "Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам төсөл" нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтын дагуу байгаль орчны үнэлгээнүүдэд тухайн замын трасс дагуух нөлөөллийн сумд, багуудын иргэдийн саналыг тусгаагүй байх тул холбогдох яамд, аймаг, сумдын дарга нарт чиглэл өгч иргэдийн саналыг тусгуулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлж, улмаар уг авсан арга хэмжээний талаарх мэдээллийг ирүүлэх;
3. "Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам" төсөл нь холбогдох бичиг баримт дутуу байж замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэн эрүүл газар хөндөж, хөрс хуулснаар их хэмжээний газар эвдэрч сүйдсэн, мөн түр хөрсийг нь хуулсан сайжруулаагүй хэсгээр одоог хүртэл нүүрс тээвэрлэн эрүүл газар эвдэж, олон салаа зам гарган бэлчээр, газар нутгийг доройтуулж, цөлжилт ихээр явагдахад нөлөөлж байгаа талаар тухайн нутгийн малчид, иргэдээс гомдол, мэдээлэл ирэх нь нэмэгдэж байна. Иймд хууль бусаар замын байгууламжийн барилгын ажил эхлүүлж, Тавантолгой-Ханги-Мандалын боомт чиглэлд шороогоор нүүрс тээвэрлэж байгаад хяналт тавьж байгаа төрийн байгууллага байгаа эсэх, аль шатны төрийн байгууллагын ямар шийдвэрээр дээрх төслийг эхлүүлсэн талаарх мэдээлэл;
4. Өмнөговь аймагт уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Терра энерги" ХХК-ийн авто зам өнөөдрийг хүртэл тавигдахгүй шороон замаар нүүрс тээвэрлэж байгаа зөрчлийг хэзээ арилгуулах талаар хариу ирүүлнэ үү.

Асуулгын заалт тус бүрт хариу тайлбарыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлж, улмаар хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.БАТ-ЭРДЭНЭ

2020000056